

Улсын Их Хурлын Тамгын газар
Хяналт шалгалт, үнэлгээний газар



Хяналт шалгалтын
мэдээ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

(2021 оны 4 дүгээр сар)

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

НӨГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

- 1.1. ТҮР ХОРОО
- 1.2. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 1.3. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 1.4. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

- 2.1. АСУУЛГА
- 2.2. АСУУЛТ

ГУРАВ. ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ
- 5.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ
- 5.3. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2021 оны 4 дүгээр сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт **17 хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 133 гишүүн** ажиллахад Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын тусалцаа үзүүлэн ажиллаж байна.

Нийт 17 ажлын хэсгээс:

- УИХ-ын тогтоолоор байгуулагдсан түр хороо 2,
- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 4,
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 10,
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

2021 оны 4 дүгээр сард шинээр байгуулагдсан ажлын хэсэг 3 байна. Үүнд:


1. Улсын Их Хурлын даргын 2021 оны №28 дугаар захирамжаар “Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсэг;

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны №3 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг;

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны №02 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг.

График 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдан одоо ажиллаж байгаа (10)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдан ажиллаж байгаа (7)




Хүснэгт 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	Түр хороо	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдан одоо ажиллаж байгаа	1	2	6	1
2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдан ажиллаж байгаа	1	2	4	-
Нийт - 17	2	4	10	1

1.1. ТҮР ХОРОО

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 -т тодорхой асуудлыг шалган судалж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулах



Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судлаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий 2 түр хороо байгуулагдан ажиллаж байна.

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулагдсан.

Түр хороо нийт 6 удаа хуралдаж хуулийн биелэлтийг нээлттэй хэлэлцсэний үр дүнд Улсын Их Хурлаас “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай” 36 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолын заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд авч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

2. “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо байгуулагдсан.

Түр хороо нийт 3 удаа хуралдаж тогтоолын биелэлтийг хэлэлцсэний үр дүнд Оюу толгойн 2.3 тэрбум долларын нэмэлт санхүүжилтийг дэмжихгүй байх чиглэлийг Засгийн газраас “Эрдэнэс Оюутолгой” ХХК болон “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн Монголын талын төлөөлөлд өгөх, “Оюу Толгой” компанийн нэхэмжлэлээр Лондонгийн Олон улсын арбитрын шүүхэд Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татсан маргаанд сөрөг нэхэмжлэл яаралтай гаргах арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг, чиглэл болгохоор /хуралдааны тэмдэглэлээр/ тогтсон.

Түр хорооны хуралдаанаар “Оюу Толгой төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, говийн бүсийн газрын гүний ус ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх байдал болон холбогдох хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалган, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг” байгуулах тухай 1 дүгээр тогтоолыг батлав.

Хүснэгт 2. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоол /КОВИД-19/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун, Ж.Мөнхбат, Н.Учрал, М.Оюунчимэг, Б.Жавхлан, Б.Чойжилсүрэн, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Бейсен, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Н.Алтанхуяг
2.	2021.03.26 №30 Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоол /Оюу толгой/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Данмдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ж.Мөнхбат, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, С.Чинзориг, Б.Энхбаяр

1.2. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ



2021 оны 4 дүгээр сарын байдлаар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 4 ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас онцолбол:

1. УИХ-ын даргын 2021 оны 14 дугаар захирамжаар байгуулагдсан “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийн хүрээнд тогтоолын 7 дэд заалт бүрээр дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Улсын Их Хурлын 2021 оны 30 дугаар тогтоолоор Түр хороо байгуулсан тул “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 14 дүгээр захирамжийг хүчингүй болгосон.

2. Улсын Их Хурлын даргын 2021 оны 28 дугаар захирамжаар байгуулагдсан “Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй эсэхийг судлах” үүрэг бүхий ажлын хэсэг нь олон нийтийн дунд үүсээд буй асуудлын талаар хууль хяналтын байгууллагуудад албан бичиг хүргүүлэн мэдээлэл авч, ажлын хэсгийн гишүүдэд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан УЕПГ-т хүргүүлэн ажиллав. Мөн ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар 4 удаа хэвлэлийн хурлыг зохион байгуулав.

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.02.09 №14 захирамж “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг (хүчингүй болсон)	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адъяаа, Ц.Анандбазар, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Ё.Баатарбилэг, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин
2.	2021.03.02 №16 захирамж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар
3.	2021.03.11 №18 захирамж Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм О.Цогтгэрэл
4.	2021.03.18 №21 захирамж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа
5.	2021.04.08 №28 захирамж Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир, Ч.Ундрэм

1.3. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2021 оны 4 дүгээр сарын байдлаар Байнгын хорооны тогтоолоор нийт 10 ажлын хэсэг ажиллаж байгаагаас: БСШУСБХ-ны эрх асуудлын хүрээнд 3, ИЦББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 1, ТБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3, ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3 ажлын хэсэг тус тус ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийх

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
1	2021.01.13 №01 тогтоол Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт "төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Ундрам, Т.Энхтүвшин
2	2021.04.27 №03 тогтоол "Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн П.Анужин Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн, Т.Аубакир, Б.Баярсайхан, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ч.Ундрам, С.Чинзориг
3	2021.04.27 №02 тогтоол "Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг.	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Ч.Ундрам, Ж.Чинбүрэн, Т.Энхтүвшин
Инновац, цахим бодлогын байнгын хороо		
4	2020.10.28-ны №02 тогтоол Эрүүл мэндийн салбар дахь цахим шилжилттэй холбоотой хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Саранчимэг
Төсвийн байнгын хороо		
5	2020.11.04 №05 тогтоол Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн
6	2020.12.30 №07 тогтоол Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн

7	2021.01.20 №01 тогтоол Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж
Хууль зүйн байнгын хороо		
8	2020.12.24 №09 тогтоол Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн
9	2021.03.15 №07 тогтоол Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир
10	2021.03.15 №08 тогтоол Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан

1.4. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийх

Хүснэгт 5. Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны тогтоолоор 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс “Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” ажиллаж байна.

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2020.10.26 №01 Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны тогтоол	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Ганболд, Г.Дамдинням, Ц.Туваан

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

2021 оны 4 дүгээр сарын байдлаар 3 дугаар сард УИХ-ын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан тавьсан 4 асуулга, 3 асуултын хариуг ирүүлсэн байна. Мөн хугацаанд УИХ-ын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад нийт 7 асуулга тавьсан байна.

Хүснэгт 6. Асуулга, асуулт тавьсан, хариу ирүүлсэн мэдээлэл (Хугацаагаар)

Хугацаа	Асуулга	Асуулт
3 сард тавьсан асуулга, асуултын хариу	4	3
4 дүгээр сард тавьсан асуулга, асуулт	7	-

2.1. АСУУЛГА



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 асуулга тавих

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д зааснаар асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө.

2021 оны 3 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад тавьсан **4 асуулгын хариуг ирүүлсэн** байна.

1. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын явц, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021.04.08-ны өдрийн ХЭГ/954 тоот албан бичгээр;

Асуулгын хариутай доорх холбоос эсхүл QR кодыг ашиглан танилцана уу.
<http://parliament.mn/files/124733>

2. УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км автозамын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулах хугацааны талаар” тавьсан асуулгын хариуг 2021.04.08-ны өдрийн ХЭГ/955 тоот албан бичгээр;

Асуулгын хариутай доорх холбоос эсхүл QR кодыг ашиглан танилцана уу.
<http://parliament.mn/n/icsyn>

3. УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021.04.16-ны өдрийн ХЭГ/1061 тоот албан бичгээр;

4. УИХ-ын гишүүн Д.Өнөрболороос Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хандан “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021.04.12-ны өдрийн 1а/1825 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн.

2021 оны 4 дүгээр сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад **нийт 7 асуулга тавьсан** байна.

1. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Н.Уртнасанд хандан “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх тохиолдолд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон бусад асуудлын талаар” 2021.04.01-ний өдрийн №13 тоот асуулга тавьсан.

2. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмын хэрэгжилтийн өнөөгийн байдал ба цаашид 8 хувийн хүүтэй зээлд харагдсан иргэдийн зээлийн хүүг 6 хувь болгон бууруулах боломж, нөхцөлийн талаар” 2021.04.06-ний өдрийн №14 тоот асуулга тавьсан.

3. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” 2021.04.12-ний өдрийн №15 тоот асуулга тавьсан.

4. УИХ-ын гишүүн Д.Ганбатаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Нүүрс тээвэрлэлтийн салбарт хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, цаашид Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” 2021.04.13-ний өдрийн №16 тоот асуулга тавьсан.

5. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандан “Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон Ховд аймагт Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн өргөтгөлийг барих, эмч ажилтнуудыг сургаж, мэргэшүүлэх ажлын явцын талаар” 2021.04.21-ний өдрийн №17 тоот асуулга тавьсан.

6. УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Коронавируст цар тахлын үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээд байгаа Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилтнуудад холбогдох асуудлын талаар” 2021.04.23-ний өдрийн №18 тоот асуулга тавьсан.

7. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 2021.04.27-ны өдрийн №19 тоот асуулга тавьсан.

2.2. АСУУЛТ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2-т асуулт тавих

2021 оны 4 дүгээр сард УИХ-ын гишүүдээс Засгийн газарт хандан асуулт тавиагүй бөгөөд харин 3 дугаар сард тавьсан **3 асуултын хариуг** ирүүлсэн байна.

1. УИХ-ын гишүүн Г.Амартүвшингээс Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж “Ард санхүүгийн нэгдлийн эрхэлж байгаа коин, криптовалютын үйл ажиллагаанд Монголбанкнаас тавьж байгаа хяналт, шалгалт, түүнтэй холбоотой үнэлгээ, дүгнэлтийн талаар” тавьсан асуултын хариу /2021.04.02 А-1/352 /

2. УИХ-ын гишүүн Г.Амартүвшингээс Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд хандаж “Ард санхүүгийн нэгдлийн эрхэлж байгаа коин, криптовалютын үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж байгаа хяналт, шалгалт, түүнтэй холбоотой үнэлгээ, дүгнэлтийн талаар” тавьсан асуултын хариу /2021.04.01 1/1232/

3. УИХ-ын гишүүн Н.Наранбаатар, Т.Энхтүвшин нараас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эрдэнэс таван толгой” ХК-г 2021-2025 онд хөгжүүлэх А6-20 бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байгаль орчны нөхөн сэргээлтийг хэрхэн төлөвлөсөн болон усны нөөц ашиглалтын зэрэг асуудлын талаар” тавьсан асуултын хариу /2021.04.12 ХЭГ/998/

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-д тайлан, мэдээлэл, илтгэл сонсох



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд Ерөнхий сайд сар бүрийн 1 болон 3 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд тогтмол мэдээлэл хийж байхаар хуульчилсан.

2021 оны 4 дүгээр сард чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын нийт 5 удаагийн мэдээлэл сонссон байна. Мэдээлэл хийхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн ажиллав.

■ Төлөвлөгөөт мэдээлэл

■ Цаг үеийн шинжтэй мэдээлэл

1. 2021.04.01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий засгийн газрын ажлын хэсгээс авч хэрэгжүүлж байгаа ажлын явцын талаар Хууль зүйн сайд Х.Нямбаатар мэдээлэл хийв.

2. 2021.04.02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний найдвартай аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх мэдээлэл хийв.

<http://parliament.mn/n/dcsyn>

3. 2021.04.09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан мэдээлэл хийв.

<http://parliament.mn/n/pesyn>

4. 2021.04.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсад үүсээд буй коронавируст цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүнгийн талаар Шадар сайд С.Амарсайхан мэдээлэл хийв.

<http://parliament.mn/n/9csyn>

5. 2021.04.30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Усны нөөц, ашиглалтын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан мэдээлэл хийв.

<http://parliament.mn/n/5syn>

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113, 114 дүгээр зүйл











УИХ-аар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан мэдээлэл, тайлан, илтгэл, танилцуулгыг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй бөгөөд холбогдох Байнгын хороо харьяаллын дагуу хэлэлцдэг.

1. Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан 6 гишүүн 12 асуулт асууж, 1 гишүүн санал хэлэв.

2. Нийгмийн бодлогын байнгын хороо 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд Коронавируст халдварын дэгдэлттэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, эмчилгээ, хүний нөөцийн хүрэлцээ, вакцинжуулалтын хангалт, нийлүүлэлтийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсов. Мэдээлэлтэй холбогдуулан 22 гишүүн 72 асуулт асуув.

3. АБГББХ-ны /КОВИД-19/-ын Түр хорооны 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсов. Мэдээлэлтэй холбогдуулан 12 гишүүн 32 асуулт асуув.

Хүснэгт 7. УИХ-д хуульд заасан хугацаанд хүргүүлэх Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл

Д/д	Байгууллагын нэр	Хариуцсан байнгын хороо	Тайлантай доорх холбоос эсхүл QR кодыг ашиглан танилцана уу.	
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Төрийн байгуулалтын байнгын хороо	-	
2	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл (Төрийн аудитын байгууллагын дүгнэлт ирээгүй байна.)	Эдийн засгийн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11072	
3	Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайлан	Төсвийн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11070	
4	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	Төсвийн байнгын хороо	http://parliament.mn/n/7wion	
5	Монголбанкны 2020 оны үйл ажиллагааны тайлан	Эдийн засгийн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11073	
6	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн байгуулалтын байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11069	
7	Үндэсний статистикийн хорооны 2020 оны үйл ажиллагааны тайлан	Эдийн засгийн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11071	
8	Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны тайлан	Эдийн засгийн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11063	
9	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	Нийгмийн бодлогын байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11066	
10	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	Нийгмийн бодлогын байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11067	
11	Төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн талаарх Монголбанкны танилцуулга.	Эдийн засгийн байнгын хороо	-	
12	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл	Хууль зүйн байнгын хороо	http://forum.parliament.mn/projects/11076	

5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ

Хүснэгт 8. Хяналтад байгаа хууль тогтоомж

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагад үүрэг, чиглэл болгосон дараах шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

	2021 оны 4 сарын байдлаар мэдээллийн сангийн хяналтад байгаа нийт хууль тогтоомж	2021 оны 4 дүгээр сард шинээр нэмж хяналтад авсан тогтоол
Хууль	121 хуулийн 436 хэсэг, заалт	-
Улсын Их Хурлын тогтоол	86 тогтоолын 275 заалт	5 тогтоолын 17 заалт
Байнгын, дэд хорооны тогтоол, тэмдэглэл	81 тогтоолын 444 заалт	Хүний эрхийн дэд хорооны 2021.04.07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгсөн, Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвлөмж болгосон 1 тогтоолын 11 заалт

5.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ



Системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн эсэхэд тавих хяналт

Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг дараах 6 байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайланд “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийсэн эсэхэд хяналт тавьж, танилцуулга санал дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлж ажиллав.

Д/д	Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага	Санал, дүгнэлт хүргүүлсэн огноо	Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн байдал
1	Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.07-ны өдөр ЭЗБХ-нд хүргүүлэв.	ЭЗБХ-ны 2021.04.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.
2	Үндэсний статистикийн хорооны 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.07-ны өдөр ЭЗБХ-нд хүргүүлэв.	ЭЗБХ-ны 2021.03.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.
3	Үндэсний аудитын газрын 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.12-ны өдөр ТБХ-нд хүргүүлэв.	-
4	Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.12-ны өдөр ТББХ-нд хүргүүлэв.	-
5	Ниймгийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.18-ны өдөр НББХ-нд хүргүүлэв.	-
6	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	2021.04.19-ний өдөр НББХ-нд хүргүүлэв.	-

5.3. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ




Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн тайланд хийсэн үнэлгээ:

Хүний эрхийн үндэсний комисс нь хуулиар заасан чиг үүргийн дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийг Ковид-19 цар тахал ба хүний эрх сэдвийн хүрээнд боловсруулан 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн тайланд үнэлгээ хийхдээ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг хэрэгжүүлэх явцад хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт хийхдээ тус хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмуудыг баримтлан ажилласан эсэх, илтгэлд дурдсан тохиолдлуудад дүн шинжилгээ хийх, ХЭҮК-оос хэрэгжүүлсэн арга хэмжээ талаар болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай холбоотой хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдлууд, тэдгээрийн шалтгааныг тогтоох, ХЭҮК-оос Улсын Их Хуралд шийдвэр гаргуулахаар ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийсэн.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх:

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээний ажлыг гүйцэтгэж байна. Үнэлгээний ажлын хүрээнд төлөвлөх болон хэрэгжүүлэх үе шатны ажлыг хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд үнэлгээ хийх шалтгаан, хүрээ, шалгуур үзүүлэлт, мэдээлэл цуглуулах хэлбэр зэргийг тодорхойлсон. Хэрэгжүүлэх үе шатны хүрээнд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий Сангийн яам болон ШШГЕГ-т шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл цуглуулах зорилгоор албан бичгийг хүргүүлсний дагуу шаардлагатай мэдээ мэдээллийг гаргуулан авч, мэдээлэлд тулгуурлан үнэлэх болон дүгнэлт, зөвлөмж өгөх үе шатны ажил үргэлжлэн хийгдэж байна.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулга бэлтгэсэн.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл нь 5 бодлогын хүрээнд нийт 20 зорилт, 127 бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг байдалд хийсэн үнэлгээний дүнгээр 75.9 хувийн хэрэгжилттэй байна.

